



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 9

Улаанбаатар хот

КОВИД-19-ын халдвараас урьдчилан  
сэргийлэх “Маскаа зүүцгээе” аян өрнүүлэх тухай


Улсын онцгой комиссын 2020 оны 4 дүгээр сарын 11-ны өдрийн XVI дугаар хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сүүлийн үед иргэд олон нийтийн дунд КОВИД-19 халдварын болзошгүй аюулаас сэргийлэх хандлага суларч байгаа тул халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх ажлыг чангатгах зорилгоор улс орон даяар “Маскаа зүүцгээе” аяныг 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 5 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд зохион байгуулсугай.

2. “Маскаа зүүцгээе” аяны удирдамжийг 2020 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн дотор боловсруулан, Улсын онцгой комиссын даргаар батлуулахыг Улсын онцгой комиссын Шуурхай штаб /хурандаа Б.Ууганбаяр/-д даалгасугай.

3. “Маскаа зүүцгээе” аяныг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА,  
ШАДАР САЙД



Ө.ЭНХТҮВШИН

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ, ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯАН